


БАТЛАВ  
 ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ  
 ТӨРИЙН НАРИЙН ДАРГА ХӨГЖЛИЙН  
 БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД  
 ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Л.МӨНХХЗҮЛ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ  
 ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ



Нэг. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд

№	Гүйцэтгэх ажил, арга хэмжээний чиглэл	Хэрэгжих хугацаа	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1.	“Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тугамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал өгч ажиллах;	II-IV улиралд	ГБХНХЯ-ны үйл ажиллагааны зардал	Саналын тоо	1	ГБХНХЯ	ХБХХЕГ ТББ
2.	Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д заасан хөнгөлөлтөд хамаарах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг шинэчлэн батлуулахад санал өгч ажиллах;	II-IV улиралд		Саналын тоо	1	ГБХНХЯ	НХБГ ТББ
3.	“Байнгын асаргаа шаардлагатай 0-18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт”-ийг шинэчлэн боловсруулахад санал өгөх;	I-IV улиралд		Саналын тоо	1	ГБХНХЯ	ЭМЯам, ЮНЭСКО-ОУБ, ТББ
4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам, хувийн туслах үйлчилгээнд тавигдах шалгуурыг шинэчлэн боловсруулах;	II-IV улиралд	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	1	ГБХНХЯ	ТББ
5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч буй иргэнд цахимаар, гэрээс, зайнаас ажиллах, оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрт бэлтгэх боломжийг бүрдүүлэх;	II-IV улиралд	Улсын төсөв		1	ХБЭХЭДТ	ХБХХЕГ ТББ
6.	Тохируулгатай ажлын байрны журам, тохирох хэрэгслийн жагсаалтыг батлахад санал өгч хамтран ажиллах;	II-IV улиралд	-	Саналын тоо	1	ХБХХЕГ	ХБХХХ
7.	“Чанартай амьдралд гэр бүлийн оролцоо” хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүлд үзүүлэх үйлчилгээг тодорхойлж, санал хүргүүлэх;	II-IV улиралд	Улсын төсөв	Саналын тоо	1	ГБХНХЯ	ХБХХЕГ ХГБХХЕГ ТББ

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах хүрээнд

8.	Хөгжлийн бэрхшээлийн талаарх болон хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг салбарын албан хаагч, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын гишүүдийг хамруулан зохион байгуулах;	I-IV улиралд	ГБХНХЯ-ны үйл ажиллагааны зардал	Сургалтын тоо	4	ГБХНХЯ	ХБХХЕГ НДЕГ ХТБХХЕГ ЭМЯ Аймаг, дүүрэг ЗДТГ ТББ
9.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах, үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг үзүүлэх арга зүйн гарын авлага, видео контент бэлтгэх;	I-IV улиралд	Бэлтгэсэн гарын авлагын тоо	5	ГБХНХЯ	ХБХХЕГ ТББ	
10.	Эрүүл мэнд, шүүх, хууль, цагдаагийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ мэдээллийн хүртээмжтэй эсэхэд судалгаа хийх, хамтран ажиглах;	II-IV улиралд	Судалгааны тоо	1	Судалгааны байгууллага	ГБХНХЯ ЭМЯ ХЗДХЯ ЦХЯ ТББ	
11.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрийн чадвар алдагтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;	I-IV улиралд	Цахим үйлчилгээний тоо	1	НДЕГ	ГБХНХЯ ЭМЯ, ЭМДЕГ	
12.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах ажлыг 5 болон 10 дугаар саруудад зохион байгуулах;	II, IV улиралд	Хамрагдсан хүүхдийн тоо	600	ГБХНХЯ	ХБХХЕГ ТББ	
13.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын зөвлөмжийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;	I-IV улиралд	Арга хэмжээний тоо	2	ХБХХЕГ	ГБХНХЯ	
14.	Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах ТББ-ын төлөөллийг Засгийн газрын журамд нийцүүлэн ил тод нээлттэй сонгон шалгаруулах, тэгш оролцоог хангах;	II улирал	Сонгон шалгаруулалтын тоо	1	ГБХНХЯ	Хараат бус баг	
15.	Хөгжлийн бэрхшээлийн талаарх зөв ойлголт, мэдлэг олгоход чиглэсэн, дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон бусад холбогдох мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар яамны цахим хуудсанд байршуулах;	I-IV улиралд	Мэдээллийн тоо	2	ГБХНХЯ	-	
16.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдээллийг нас, хүйс, бэрхшээлийн төрөл, хэлбэрээр гаргаж, Үндэсний зөвлөлд хүргүүлэх;	IV улиралд	Судалгааны тоо	1	ГБХНХЯ	НДЕГ, ХБХХЕГ, ХТБХХЕГ, ХХҮЕГ, ХАБЭМТ, ХАХНХС,СХ	

17. Салбарын Байгууллагад хүртээмжийн үнэлгээ хийж, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангах;	II-IV Улиралд	-	Үнэлгээ хийсэн Байгууллагын тоо	10	ГБХНХЯ, НДЕГ, ХБХХЕГ, ХГБХХЕГ, ХХҮЕГ, ХАБЭМТ, ХАХНХС,СХ	ХБХХЕГ ТББ
18. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт оролцооны зураглалыг эцэслэн боловсруулж, холбогдох хуульд оруулах санал боловсруулах;	II-IV Улиралд	Улсын төсөв	Саналын тоо	1	ГБХНХЯ	ХБХХЕГ ТББ
19. Гэр бүлийг дэмжих цогц үйлчилгээний төвөөр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүлд гэр бүлийн боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулахад хамтран ажиллах;	II-IV Улиралд		Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	200	ХГБХХЕГ	ГБХНХЯ ТББ